



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/34

Бор-Өндөр сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг Нэгдүгээр хавсралтад зааснаар шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал / Т.Эрдэнэзаяа/-д үүрэг болгосугай.


3. Газар эзэмшүүлэх гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлж авсан иргэдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2022 оны А/111 тоот захирамжийн иргэн Э.Эрдэнэбатад холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ



Сумын Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/34-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчдийн мэдээлэл

Д/д	Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын хэмжээ /м ²	Эзэмших хугацаа	Газрын байршил хаяг	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Эрх шилжүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр	Эрх шилжүүлэх үндэслэл
1	Боржигин Зоригтбаатар Мөнгөнчавхадас	ЛН85102112	56	1	1-р баг Бор-Өндөр, Үйлдвэрийн зам-1 гудамж, 101г тоот	2322003620	Худалдаа, үйлчилгээ	Улаан сахиус Эрдэнэбаатар Эрдэнэбат СЦ86122611	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2025.09.02/0449
2	Халх Очирхуяг Эрдэнэтуяа	СЮ77021162	36	1	1-р баг Бор-Өндөр, Үйлдвэрийн зам-1 гудамж, 101д тоот			Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2026.01.16/0026	